

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ
1, 2 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 03 дугаар сарын 07

Улаанбаатар хот

1	2		3	4	5	6
Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
1	1	II.. Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын визийг цахимаар авах улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах, гадаадын бусад улсыг нэмж хамруулах асуудлыг холбогдох байгууллагын саналыг харгалзан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав.	2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 01 дүгээр тэмдэглэл 2023-01-04 Дугаар 2023_01	Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах 34 улсын иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээс дээрх улсыг хаслаа. Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг цахим визийн системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэдэд визийг цахимаар олгон ажиллаж байна.	100	
	2	II.3. Тогтоол батлагдсантай холбогдуулан гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн),		Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53 дугаар хамтарсан тушаал батлагдсантай холбогдуулан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, 02 дугаар сард Монгол улсын “визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 4 улсын 428 иргэнд цахим виз олгон, 67 иргэнд татгалзсан байна.	100	

1	2	3	4	5	6
	Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар) нарт даалгав.				
Хэсгийн дундаж: 100 хувь					
Нийт дундаж 100 хувь					

--oo0oo--